



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 82

Улаанбаатар  
хот

“Шинэ төмөр зам” төслийн  
санхүүжилтийн тухай

Эрчим хүчний тухай хуулийн 5.1.1, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 28/20 дугаар зөвлөмжийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс “Шинэ төмөр зам” төслийг санхүүжүүлэх 400 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн эхний ээлжинд шаардагдаж байгаа 200 сая ам.доллартай тэнцэх төгрөгийг Хөгжлийн банкаар дамжуулан 2013 онд гаргахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгаж, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан санхүүжилтийг “Шинэ төмөр зам” төслийг хэрэгжүүлэх компанид төрөөс оруулсан хувь хөрөнгөд тооцон зохих журмын дагуу бүртгэхийг Зам, тээврийн сайд А.Гансүх, Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Батзаяа)-д тус тус даалгасугай.

3. Бондын хөрөнгийн үндсэн болон хүүгийн дунд хугацааны төлбөрт шаардагдах хөрөнгийг тухай бүр улсын төсөвт тусган шийдвэрлэж байхыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ

Эдийн засгийн хөгжлийн сайд

Н.БАТБАЯР